



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/65

Сүхбаатар сум

Удирдах ажилтны "Мэдээллийн цаг" нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", "е", Монгол Улсын Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.5, 6 дугаар зүйлийн 6.1.1, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны "Сахилга хариуцлагыг чангатгах тухай" 01 тоот албан даалгавар, аймгийн Засаг даргын 2016 оны "Ажлын хариуцлага, ажлын цаг ашиглалтыг сайжруулж, төрийн үйлчилгээний шуурхай байдлыг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай" 05 тоот албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төр, төсвийн байгууллагуудын харилцан туршлага солилцох, мэдээ, ажлын уялдаа холбоог сайжруулж, мэдээллийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор "Мэдээллийн цаг" арга хэмжээг 2020 оны сар бүрийн эхний Даваа гараг бүрийн 10.00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын их танхимд зохион байгуулсугай.

2."Мэдээллийн цаг" арга хэмжээний хуваарь, оролцох байгууллагуудын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3.Тус арга хэмжээнд салбарын хэмжээнд тухайн сард зохион байгуулагдсан онцлох болсх шинэлэг мэдээлэл болохуйц үйл ажиллагааныхаа талаарх товч мэдээллийг танилцуулах, хүндэтгэх болон зайлшгүй шалтгаанаар оролцох боломжгүй тохиолдолд урьдчилан аймгийн Засаг даргын Тамгын газарт болон харьяа нэгжид мэдэгдэж ажиллахыг байгууллагын удирдлагуудад, удирдлага зохицуулалтаар хангаж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ө.Сувдаа/-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ

C:\users\albanbichig2020\zahiramjA4.docx

430801181

Сэлэнгэ аймгийн Засаг даргын
2020 оны 02 дугаар сарын 20 -ны
өдрийн А/65 дугаар захирамжийн
хавсралт

УДИРДАХ АЖИЛТНЫ "МЭДЭЭЛЛИЙН ЦАГ"-ИЙН ХУВААРЬ-2020

Сар/өдөр	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
1												
2			■								■	
3								■				
4					■							
5										■		
6				■			■					
7									■			■
8						■						

ОРОЛЦОХ БАЙГУУЛЛАГУУД

1. Байгаль орчин, аялал жуулчлалын газар
2. Биеийн тамир спортын газар
3. Боловсрол, соёл урлагийн газар
4. Гаалийн газар
5. Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
6. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
7. Мэргэжлийн хяналтын газар
8. Мал эмнэлгийн газар
9. Онцгой байдлын газар
10. Орон нутгийн өмчийн газар
11. Санхүүгийн хяналт, аудитын алба
12. Стандарт, хэмжил зүйн хэлтэс
13. Статистикийн хэлтэс
14. Татварын хэлтэс
15. Ус, цаг уур орчны шинжилгээний газар
16. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
17. Хүнс, хөдөө аж ахуйн газар
18. Цагдаагийн газар
19. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
21. Эрүүл мэндийн газар
22. Ниймгийн даатгалын хэлтэс
23. Улсын бүртгэлийн хэлтэс
24. Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газар
25. Аймгийн нэгдсэн эмнэлэг
26. Аймгийн нийтийн номын сан

- 27.Аймгийн "Сэлэнгийн долгио" чуулга
- 28.Аймгийн нэгдсэн музей
- 29.Сэлэнгэ Барилга Захиалагч ОНӨААТҮГ
- 30.Сэлэнгэ энерго ОНӨААТҮГ
- 31.Урсгал ус ОНӨААТҮГ
- 32.Сэлэнгэ-Үйлчилгээ ОНӨААТҮГ
- 33.Сэлэнгэ орон сууц ОНӨААТҮГ
- 34.Автотээврийн үндэсний төвийн Сэлэнгэ аймаг дахь салбар
- 35.Сэлэнгэ АЗЗА ТӨХК
- 36.Хилийн мэргэжлийн хяналтын алба
- 37.Гадаадын иргэн харьяатын Хойд бүс дэх газар
- 38.Хилийн цэргийн 0243-р анги
- 39.Хилийн цэргийн 0101-р анги
- 40.Дархан-Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК
- 41.Мэдээлэл холбоо сүлжээ ХХК-ний Сэлэнгэ аймаг дахь газар
- 42.Тужийн нарсны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа
- 43.Сэлэнгэ шуудан үйлчилгээний газар